БАРААНЫ АНГИЛАЛ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Н.ОТГОНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин: Суурь түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрэх түвшин | Гүйцэтгэлийн түвшин: Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | | | |
| 1. | Гаалийн зуучлал | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 95.8 | Эхний хагас жилд:<br><br>1.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах асуудлыг тусгай зөвшөөрлийн цахим системд шийдвэрлэсэн байна.<br><br>2.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах стандартыг боловсруулах<br><br>3.Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавьсан байна.<br><br>4.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний алдаа суурь түвшингээс 5-аас | 1.<br><br>Зөвшөөрөл олгосон: Эс И Эй форвард ХХК, Чой энд Хаку ХХК, Шип смарт ХХК, Ханбогд Хөгжил ХХК зэрэг 4 ААН-ийн тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хянан баталгаажуулж, Сангийн яаманд цахимаар болон 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01/1176 тоот албан бичгээр хүргүүлсэн. Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 73 тоот тушаалаар 3 жилийн хугацаатай зөвшөөрөл олгосон.<br><br>Сангийн яаманд хүргүүлсэн: Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр дуусгавар болох Смарт прогресс ХХК, Ануурмонгол ложистик ХХК, Бест прэйт ХХК-иудад Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасны дагуу сунгалтын хүсэлтээ хуулийн хугацаанд цахимаар ирүүлэхийг 02-2.1/1144, 1211, 1212 дугаартай албан бичгүүдээр мэдэгдсэн. Мөн тусгай зөвшөөрөл хүссэн Илт смарт логистикс ХХК, Омни бест ложистикс ХХК, Хас таван хүрд ХХК, Тэнгэр экспресс ХХК-иудын хүсэлтийг хянаж, цахимаар болон 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/1739 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн, хянагдаж байна.<br><br>Гаалийн байгууллагад хянагдаж байгаа: Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусгавар болсон Пик Пак Ворлдвайд ХХК-д Зөвшөөрлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасны дагуу сунгалтын хүсэлтээ хуулийн хугацаанд цахимаар ирүүлэхийг 02-2.1/1651 дугаартай албан бичгээр мэдэгдсэн. Мөн тусгай зөвшөөрөл хүссэн Эн Би Ти Ти ХХК, Стора централ ХХК, Рейлнетворк ХХК, ВИП МК ХХК-иудын хүсэлтийг хянаж байна.<br><br>2. 2019 онд Гаалийн зуучлагчийн стандартыг боловсруулж, Стандартчилал хэмжил зүйн газарт хүргүүлж байсан ч тухайн үед стандартыг танайхаас боловсруулахгүй гэдэг хариуг ирүүлсэн. ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн | 01.01-06.05 | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дээш хувиар буурсан байна. | зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын шинэчлэн найруулсан журмын төслийн 3 дугаар зүйлд тавигдах шаардлагыг тусган оруулсан.<br>3. ГЕГ-ын даргын 2022 оны А/341 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1.1-д заасан зөрчил гаргасан 3 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг ГЕГ-ын даргын 2024 оны А/06, А/211 тушаалаар, 7.1.3 дахь заалтыг зөрчсөн 2 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг ГЕГ-ын даргын 2024 оны А/244 дүгээр тушаалаар тус тус хүчингүй болгосон.<br>-Гаалийн газар, хороодын дарга нарт 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 02-2.1/976 тоот албан бичгээр гаалийн бүртгэгдсэн мэргэжилний анхан шатны сургалтад хамрагдаж, системд ажиллах эрх нээлгэсэн гаалийн бүртгэгдсэн мэргэжилнүүдийг нэрсийг хүргүүлж, дадлага, туршлага хуримтлуулах, гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эхний 6 сарын хугацаанд томилогдсон газар тогтвор суурьшилтай ажиллуулах, зөвхөн тухайн гаалийн газар хорооны хяналтад байгаа барааг мэдүүлэхэд анхаарч, хяналт тавьж ажиллахыг мэдэгдсэн.<br>-Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоонд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 02-2.1/250 дугаартай албан бичгээр гаалийн газар, хороодод үйл ажиллагаа явуулж байгаа гаалийн зуучлагч байгууллагын гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн 2023 оны сүүлийн хагас жилийн үнэлгээг тусгай зөвшөөрлийн цахим системд дүгнүүлэх болсон тухай, хэрхэн нэвтэрч, өөрийгөө үнэлэх талаар заавар зөвлөгөөг өгсөн мэдэгдлийг хүргүүлсэн. Мөн гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх авсан ажилтнуудыг дадлага, туршлага хуримтлуулах эхний 6 сарын хугацаанд томилогдсон газар тогтвор суурьшилтай ажиллуулах, зөвхөн тухайн гаалийн газар хорооны хяналтад байгаа барааг мэдүүлэхийг зуучлагч байгууллагад мэдэгдэж ажиллахыг 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 02-2.1/975 тоот албан бичгээр хүргүүллээ.<br>-Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний "Өөрийн үнэлгээний хуудас"-ыг тусгай зөвшөөрлийн цахим системд нэвтрүүлж, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн 2023 оны сүүлийн хагас жилд хийсэн ажлыг "Өөрийн үнэлгээний хуудас"-аар баталгаажуулж дүгнэлээ. 2023 оны сүүлийн хагас жилд идэвхтэй ажилласан /эрх хүчингүй болсон, жирэмсний амралт болон бусад шалтгаанаар ажлаас түр чөлөөлөгдсөн, гарсанаас бусад/ нийт 270 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнийг дүгнэж, нэгтгэл дүнг гаалийн газар, хороодоос албан бичгээр авч ажилласан.<br><br>3.Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний давтан болон анхан шатны сургалтын талаар:<br>-2023 оны сүүлийн хагас жилд гаалийн зуучлагч байгууллага, шинээр зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхээр зөвшөөрөл хүсч байгаа аж ахуйн | | |

нэгж, бусад гадаад худалдаа эрхлэгч өөрөө мэдүүлэгч байгууллагаас анхан шатны сургалтад 63 ААН-ээс 131 ажилтныг хамруулахаар хүсэлт ирүүлснийг судлан ЗУГ-ын дарга Б.Хосбаярт танилцуулсан. Сургалтын төвөөс 2024 онд зохион байгуулсан гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад 102 хүн хамруулж, Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/126 дугаар тушаалаар гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрхийг 2 жилийн хугацаатай олгосон. Суралцагчдын 75 нь гаалийн зуучлагч байгууллагын ажилтан, 18 нь гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэхэд 2 гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнтэй байх шаардлагыг хангах, 9 нь барааг гаальд өөрөө мэдүүлэгч аж ахуйн нэгжээс ажилтнаа сургаж, мэргэшүүлэх зорилгоор хамруулсан байна.
-Сургалтын төвтэй хамтран 2024.03.25-04.12, 04.15-.05.03-ны хугацаанд 2 удаа давтан сургалтыг зохион байгуулж ГЕГ-ын даргын 2024 оны А/210 тушаалаар 80 ГБМ, А/246 тушаалаар 32 ГБМ-ийн эрхийн хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасан. 2024.06.03-21 хугацаанд 3 дахь ээлжийн давтан сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.
-Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдэд зориулсан анхан шатны болон давтан сургалтанд 2024 оны 02 сарын 02-ны өдөр, 04 сарын 05, 04 дүгээр сарын 25--ны өдрүүдэд БАУХ-ийн ГУАБ Н.Цолмон, ГУБ Ц.Урантуул нар барааны ангилал, анхаарах асуудлууд сэдвээр хичээл зааж, нийт 214 оюутан хамрагдсан.

4. 2023 оны эхний 06 сарын 05-ны өдрийн байдлаар нийт 1017985 бичлэг бүхий бараанд экспортын 244418, импортын 122744, нийт 367162 гаалийн мэдүүлгээр гаалийн бүрдүүлэлт хийсэн. 2024 оны эхний 06 сарын 05-ны өдрийн байдлаар нийт 1210060 бичлэг бүхий бараанд экспортын 312791, импортын 173825 нийт 486616 гаалийн мэдүүлэг бичигдсэн байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад бичлэгийн тоо 192075 буюу 15,9%, экспортын 68373 буюу 21.8%, импортын 51081 буюу 29.4%, нийт гаалийн мэдүүлгийн тоо буюу 15,8%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Барааны бичлэг болон гаалийн мэдүүлгийн тоонд цахим /өөрөө/-аар болон гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнээр мэдүүлснийг дараах байдлаар харуулвал:

| | 2023 оны эхний хагас жил | | | | 2024 оны эхний хагас жил | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Цахим/өөрөө/ | | ГБМ | | Цахим/өөрөө/ | | ГБМ | |
| | тоо | хувь | тоо | хувь | тоо | хувь | тоо | хувь |
| Бич | 315772 | 31.1% | 702213 | 68.9% | 396434 | 32.7% | 813626 | 67.3% |
| Мэд | 226865 | 61.8% | 140297 | 38.2% | 263131 | 54.1% | 223468 | 45.9% |

-2023 оны мөн үеийн байдлаар 1017985 бичлэг бүхий бараанд нийт

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 367162 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн. Тайлант үеийн байдлаар 28746 мэдүүлгийг засварт буцаасан бөгөөд үүнээс гаалийн мэдүүлэгчээс шалтгаалахгүйгээр 5073 гаалийн мэдүүлэг буцаагдаж, нийт алдаатай мэдүүлгийн тоо 23673 байна. Нийт алдаатай мэдүүлгийн тоог нийт барааны бичлэгийн тоонд харьцуулахад 2.3%, нийт мэдүүлгийн 6,4%-ийг эзэлж байна. Алдаатай мэдүүлгийн 5271 нь өөрөө барааг гаальд мэдүүлэх, 18402 нь ГБМ-ээр дамжуулан мэдүүлсэн. ГБМ-ийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулахад 1.8 хувь, өөрөө мэдүүлсэн алдааг нийт бичлэгт харьцуулахад 0,5 хувийг эзэлж байна.<br>2024 оны тайлант үеийн байдлаар 1210060 бичлэг бүхий бараанд нийт 486616 гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн. Тайлант үеийн байдлаар 34787 мэдүүлгийг засварт буцаасан бөгөөд үүнээс гаалийн мэдүүлэгчээс шалтгаалахгүйгээр лабораторийн дүгнэлт, экспертизийн акт оруулах, зөрчлийн улмаас засварт буцаасан гаалийн мэдүүлгийн тоо 6900 байна. Алдаатай гаалийн мэдүүлгийн тоо 27887 байгаа бөгөөд нийт алдаатай мэдүүлгийн тоог нийт барааны бичлэгийн тоонд харьцуулахад 2,3%, нийт мэдүүлгийн 5,7%-ийг эзэлж байна. Алдаатай мэдүүлгийн 6208 нь өөрөө гаальд мэдүүлэх, 21679 нь ГБМ-ээр дамжуулан мэдүүлсэн. ГБМ-ийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулахад 1,7%, өөрөө мэдүүлсэн алдааг нийт бичлэгт харьцуулахад 0,5%-ийг эзэлж байна.<br>Ийнхүү нийт алдаатай мэдүүлгийн тоо 2023 оны тайлант үеэс 15.1%-иар өссөн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад барааны бичлэг 15,87%, мэдүүлгийн тоо 24,5%-иар өссөн нь нөлөөлсөн байна. ГБМ-ийн мэдүүлгийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулсан мөн үеийн дүнгээс 0,1%-иар буурсан, цахимаар өөрөө гаальд мэдүүлэгчийн алдааг нийт бичлэгийн тоонд харьцуулсан мөн үеийн дүнтэй ижил байна. | | |
| **Зорилт 4.“Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”** | | | | | | | |
| 2. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 95.8 | Бүрдүүлэлтийн цахим төв байгуулагдсантай холбогдуулан “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан байна. | Гаалийн бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлэх, гаалийн зуучлагчийн үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх зорилгоор “Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам”-ыг шинэчлэн найруулах шаардлага үүссэн. Журмыг төслийг боловсруулсан. Тус төслийг ГЕГ-ын удирдлагуудад танилцуулж, ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас санал авахаар 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 2-2.1/050 дугаартай дотоод зурвасаар, гаалийн газар, хороодоос 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 02-2.1/988 дугаартай албан бичгээр, Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоонд 02-2.1/987 дугаартай албан бичгээр хүргүүлсэн, гадаад худалдаанд оролцогч иргэн аж ахуйн нэгжээс санал авахаар https://customs.gov.mn/-д байршуулсан болно. ЗББНДБ, гаалийн газар, хороод, Монголын гаалийн зуучлагчийн мэргэшсэн холбооноос саналуудыг авч нэгтгэн ажиллаж байна. 2023 онд “Гаалийн цахим бүрдүүлэлт, хяналт шалгалтын үйл ажиллагааг | 01.01-06.05 | 94 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оновчтой зохион байгуулах, сайжруулах, эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө" батлагдсантай холбогдуулан тус төлөвлөгөөний Зорилт.4 Хуулийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг сайжруулах зорилтын хүрээнд Гаалийн зуучлагч, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд мониторинг оруулсан, мөн Бүрдүүлэлтийн цахим төв байгуулагдаж, бүрдүүлэлтийг нэг цэгт төвлөрүүлж цахимаар мэдүүлэх болсон нь ГЕГ-ын даргын 2022 оны "Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журам"-ыг өөрчлөх, шинэчлэх шаардлагатай болсон. БАУХ-ээс журмын төслийг боловсруулж, санал авахаар ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллагаас 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 2-2.1/050 дугаартай дотоод зурвасаар, гаалийн газар, хороодоос 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 02-2.1/988 дугаартай албан бичгээр, Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоонд 02-2.1/987 дугаартай албан бичгээр хүргүүлсэн, гадаад худалдаанд оролцогч иргэн аж ахуйн нэгжээс санал авахаар https://customs.gov.mn/-д байршуулсан болно. ЗББНДБ, гаалийн газар, хороод, Монголын гаалийн зуучлагчийн мэргэшсэн холбооноос саналуудыг авч нэгтгэсэн.<br>Журмын төслийн хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар 08-ны зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Гаалийн ерөнхий газрын бүтцийн нэгж, дэргэдэх газар, гаалийн газар хороод буюу ЗУГ, ХБГ, ТОГ, ХШҮДАГ, ЗТГ, ХХ, БАУХ, БЦТ, УБГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ-аас 24 албан хаагч, гаалийн зуучлагч байгууллагыг төлөөлж 27 ААН-ийн 28 албан тушаалтан нийт 52 хүн оролцлоо. Хэлэлцүүлгийн явцад хэлэлцүүлэгт оролцогчдоос 9 асуудлыг хөндөж асуулт тавьсан. Санал асуулгын хуудсаар 20, нийт давхардсан тоогоор 29 асуудлыг хөндөж санал ирүүлснийг дахин нягталж эцсийн байдлаар боловсруулсан хянуулахаар Хуулийн хэлтэст 2-2.1/102 тоот дотоод зурвас хүргүүлсэн. Мөн Сангийн яаманд 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 01/1841 дугаартай албан бичгээр журмын төслийг хянуулахаар хүргүүлсэн. МЗХ-аар хэлэлцүүлэхэд бэлэн болсон. | | |
| 3. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 95.8 | ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, Шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлж ажилласан байна. | БАУХ-ийн гаалийн зуучлагчийн асуудал хариуцсан ГУБ-ийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж байна.<br><br>Гаалийн захиргаа, дотоод ажлын систем /CERP/-д БАУХ-т өгсөн үүрэг даалгаврын гаалийн зуучлагчийн асуудалтай холбоотой өгөгдсөн биелэлтийг оруулж, гаалийн газар, хороодод 1 чиглэл хүргүүлсэн. | 01.01-06.05 | 92 |
| 4. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100 | Ажлын цагийн хоцролт, тасалдалгүй аужилласан | Хөдөлмөрийн дотоод журмын дагуу цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид ирсэн, явсан бүртгэлээ бүртгүүлж хэвшсэн. Ажлын цагийн тасалдалгүй ажилласан болно. | 01.01-06.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байна. | | | |
| 5. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 95.8 | 1.Цаг үеийн шинжтэй арга хэмжээ, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан байна.<br>2.Гаалийн байгууллагын 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажилласан байна. | 1.БОАЖСайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 09/190 тоот тушаалаар Хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААН, байгууллагын татвар хураамжаас чөлөөлөх боломжийг судлах, тэдгээрийн импортолсон болон үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнд хаягдлын татвар ногдуулах, тооцоо, судалгааг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан. 2 удаагийн онлайн, 2 удаагийн уулзалтад оролцсон, гаалийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг хүргүүлж ажилласан.<br><br>2.<br>- ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд үнэн, зөв мэдүүлсэн.<br>- Гаалийн зуучлагчийн журмын төслийн боловсруулж санал авахаар Монголын гаалийн зуучлалын мэргэшсэн холбоонд 02-2.1/987 дугаартай албан бичгээр хүргүүлсэн, гадаад худалдаанд оролцогч иргэн аж ахуйн нэгжээс санал авахаар https://customs.gov.mn/-д 2023.03.15-04.15-ны хугацаанд байршуулсан болно. Журмын төслийн хэлэлцүүлэгт 2024 оны 05 дугаар 08-нд зохион байгуулах талаар https://customs.gov.mn/-д зарлалыг байршуулсан. Хэлэлцүүлэг ил тод, нээлттэй зохион байгуулагдсан.<br><br>3. Архив, албан бичиг хөтлөлтийн систем https://edoc.ecustoms.mn/-д 2023 оны эхний хагас жилийн байдлаар гаалийн газар, хороод, гаалийн зуучлагч байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн 229 албан бичиг, 2 өргөдлийг хүлээн авч, 17 албан бичгийг төлөвлөн гаалийн газар, хороод, гаалийн зуучлалын холбоо, иргэн, аж ахуй нэгжүүдэд хүргүүлсэн.<br><br>4.Гаалийн зуучлагч, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнтэй холбоотой асуудлаар ирсэн, явсан бичгийг архивын стандартын дагуу 4 боть баримтыг архивын нэгж үүсгэн хүлээлгэн өгсөн. | 01.01-06.05 | 90 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | 7 хоног бүр зохион | Хэрэгжилт, гүйцэтгэлээр, | | Зохион байгуулагдсан | Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын нэгжүүдээс долоо хоногийн баасан гараг бүрт зохион байгуулсан сургалтуудад тогтмол хамрагдаж, | 01.01- | 93 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулдаг сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэх | сургалтын тоогоор | 92 | сургалтад хамрагдсан байна. | шинэлэг мэдлэг, мэдээллийг олж авч байна. | 06.05 | |
| 2 | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 92 | Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлсэн байна. | Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих журмыг шинэчлэн батлуулахтай холбоотойгоор ОХУ, Турк, Япон, Хятад улсын гаалийн зуучлагчийн үйл ажиллагаатай холбоотой хууль, журам, туршлагыг судалсан.<br><br>- 2024.04.19-нд шинээр батлагдсан Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль<br><br>-Төмөр замын тээвэр зуучлалын үйл ажиллагааны журам /ЗТХСайдын 2020 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн А/154 тоот тушаал/ | 01.01-06.05 | 93 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

БАРААНЫ АНГИЛАЛ ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ........................ /Н.ОТГОНЦЭЦЭГ/

2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

# ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ НАРАНГЭРЭЛИЙН ОТГОНЦЭЦЭГИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Барааны ангилал, үнэлгээний хэлтэс

## 1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1: Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах** | | | | | |
| 1. | Гаалийн зуучлал | 57.1 | 8 | 65.1 | |
| **Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэхэд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 55.8 | 10 | 65.8 | |
| 2 | Үүрэг даалгаврын биелэлт | 54.4 | 10 | 64.4 | |
| 3 | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |
| 4 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | 53 | 10 | 63 | |
| **Дундаж оноо: 65.6** | | | | | |

## 2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийг хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1. | 7 хоног бүр зохион байгуулдаг сургалтад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэх | 93 | 14 | |
| 2. | Шинээр гарсан хууль тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | 93 | 14 | |
| **Дундаж оноо: 14** | | | | |

### 3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1. | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2. | Асуудал шийдвэрлэх | 5 | |
| 3. | Хариуцлагатай байдал | 5 | |
| 4. | Дүн шинжилгээ хийх | 5 | |
| 5. | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 6 | Мэргэжлийн ур чадвар 1. | 5 | |
| | **Дундаж оноо: 5.7** | | |

### 4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1. | Хандлага, ёс зүй | 8 |
| 2. | Багаар ажиллах | 8 |
| 3. | Харилцаа | 8 |
| | **Дундаж оноо: 8** | |

### 5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *(70 хүртэлх оноо)* |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | *(15 хүртэлх оноо)* |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | *(7 хүртэлх оноо)* |
| 4. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | *(8 хүртэлх оноо)* |
| 5. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *(.....оноо)* |
| | **Нийт оноо = 93.3** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | |

***Үнэлгээ өгсөн:*** ***Нэгжийн дарга***

Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч ………………………… /Ч.Чимгэрэл/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.06.10
*(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Төрийн жинхэнэ албан хаагч:***

Барааны ангилал, үнэлгээний хэлтсийн гаалийн улсын байцаагч ………………………… /Н.Отгонцэцэг/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.06.10
*(огноо)*

***Үнэлгээг хянасан :***

*Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:*

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ………………………… /Г.Энхтайван/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.07.26 *(огноо)*

*Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:*

Хүний нөөцийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч ………………………… /Ж.Баясгалан/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.07.27 *(огноо)*

***Үнэлгээг баталгаажуулсан:*** ***Төсвийн шууд захирагч***

Дарга ………………………… /Р.Отгонжаргал/

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2024.07.27
*(огноо)*